

БНМАУ-ТАЙ АНУ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТАЛААР АМЕРИКИЙН ЭРДЭМТЭД, АЛБАНЫ ХҮМҮҮСИЙН БАРИМТАЛСАН ҮЗЭЛ, ХАНДЛАГА

Ц.Алтангэрэл*

Abstract: During the 1950's, the competition between the USSR and PRC for Mongolia intensified which impacted the U.S. policy toward Asia. Therefore, U.S. President, John F. Kennedy's administration initiated diplomatic relations with the People's Republic of Mongolia by setting up a diplomatic mission in Ulaanbaatar as a "listening post" during the Sino-Soviet split, to collect important information regarding these countries. Prior to the Kennedy administration, and during the Eisenhower administration, some American scholars, researchers and newspaper correspondents from the "New York Times" and other officials visited our country. Their purpose was to collect necessary information about Mongolia which was developing a socialist society. The books, research articles, newspaper columns and information written by these people impacted the views and tendencies of the U.S. policymakers regarding Mongolia. This article covers the views of the influential scholars and officials who met and exchanged their opinions with the political and government leaders of socialist Mongolia.

Keywords: USA, PRM, R. Rupen, H. Salisbury, O. Lattimore, Posh, Mamnsfield, Diplomatic Relations, UN, Cold War, USSR, PRC

АНУ-ын эрдэмтэн Роберт А.Рупен 1958 оны 9-р сард Монгол Улсад 16 хоног аялж, 1959 оны 9-р сард дахин Монголд 7 хоног болохдоо Монголын талаар ихээхэн мэдээлэл цуглуулж, АНУ-ын нэртэй судалгааны олон байгууллагуудаас дэм авч, Монгол судлалын эрдмийн нөр их ажлаа хийсэн байна. Монголын уншигч олонд зориулан бичсэн номынхоо оршилд тэсч үлдэхүйн талаар өгүүлжээ.

“... Та биднийг сүүлчийн Могикан гэж бодож байна уу? гэж нэгэн Монгол хүн 42 жилийн өмнө Улаанбаатарт надаас асуусан билээ. Энэ асуултад хариулахын тулд бие, мах бодийн тэсч үлдэх, соёлын хувьд тэсч үлдэх гэсэн хоорондоо маш том ялгаатай 2 зүйлийг анхаарууштай. 100 жилийн өмнө Монголчуудыг тэсч гарах уу, үгүй уу гэж нухацтай хэлэлцэх нь тун ердийн асуудал байлаа. Тоо баримтад илэрхий итгэх аргагүй хэдий ч “Тадаад Монгол” гэгчид суух хагас сая гаруйхан Монгол толгой дараалан үхээд дуусах нь уу гэж бодогдохоор байжээ. Өвчин тахал газар авсан, анагаан эмчлэх арга нь бүдүүлэг байснаас олон ажиглагчид тэдний мөхөхийг зөгнөн хэлэхэд хүрч байлаа. Гэвч хувьсгал гарснаар тэр саар хандлага эргэж, намайг 1958 онд Монголд очиход Монголын хүн ам сая гаруй болж өссөн байв. Шинэ бие даасан Монгол өдгөө 2000 онд 2 сая гаруй хүн амтай болжээ. Соёлын хувьд (мөн улс төрийн хувьд) тэсч үлдэх асуудал бат нот баталгаатай мэт

* ШУА-ийн ОУХХ-ийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

санагдавч ноцтой аюул тулгараад байгаа бололтой. Орост Чечень, Хятадад Төвдийн хувь заяа Монголын хөршүүдэд түгшүүрийн дохио өгч байна. Буриад Монгол, Халимагууд Оросчлогдож, Өвөр Монголчууд хятадчлагдсанаар Монголыг урхихаа урхин гогцоо чивчирч байна. Орос, Хятад хоёрын ирээдүйн хөгжил дэх зарим тодорхой боломжит хандлагыг сайтар, тун няхуур авч үзүүштэй, бүхий л шинж тэмдэг цөмөөрөө өөдрөг байж чадахгүй байна...” гэжээ. “Монголыг яагаад судалж байна вэ гэдэгтээ холбогдуулан нэг оюутан “...бид Монголын төлөө санаа тавиад яах юм бэ? Тэр чинь дэндүү хол, дэндүү жаахан, дэндүү ач холбогдолгүй юм биш үү?” гэж надаас асууж билээ. Миний тэгэхэд өгсөн, одоо ч энэ мэт асуултад өгч байгаа хариу гэвэл ...Монголчууд шиг бүлэг нь “соёлын ген”-г авч явдаг, дэлхийг олон өнгөтэй болгож байдаг, олон янз байх нь “дэлхийн генийн сан”-г хүчтэй болгодог гэдэг юм. Ижилгүй шинж төрхтэй, хосгүй өвөрмөц Монгол алга болвол эмгэнэлт явдал болохсон. Хүний соёлыг хадгалах нь эцсийн бүлэгт араатан чоно, цаст уулын цагвар, сац бас ямар ч амьтныг авран хамгаалах лугаа адил чухал билээ. Өөр нэг учир баримт бол Монгол стратегийн хувьд чухал нутаг дэвсгэр “харуулын цэг” байгаа юм,. Миний хувьд Монголыг судалж, Монголын тухай бичих нь ямагт шагнал байдаг билээ. Монголын тухай тээж явдаг гунигт төсөөллийнхөө нэгийг 1987 онд Өвөр Монголд үзсэн бөгөөд Халх Монголд ч иймэрхүү явдал бас байгааг та бүхэн мэдэж байгаа. ²

АНУ-ын эрдэмтэн Р.А. Рупен Монгол оронд айлчилсан тухай сэтгэгдэлийн³ талаар дараахи архивын баримтанд ингэж дурдсан байна. “Богино хугацааны айлчлал хийхэд надад хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн зүйл бол Монголын ард түмний найрсаг зочломтгой байдал бөгөөд тэдний сайхан сэтгэл нь миний зүрх сэтгэлийг эзэмдсэн юм. Та бүхэнд маш их баярлаж байдаг шүү. Хоёрт Монгол орны байгалийн үзэсгэлэн гоо ялангуяа Богд уул, Өвөрхангай аймгийн Орхон голын хөндий, Улаан цутгалан сэтгэлийг минь татсан. Мөн танай орны боловсролын систем өндөр сэтгэгдэл төрүүлсэн. Улсын номын сан, төв музей, драмын театр зэрэг соёлын дэвшлийг харуулсан. Орон нутгийн удирдлагууд сайн бэлтгэгдсэн, мэдлэг чадвар сайтай боловсон хүчин гэдэг нь харагдаж байлаа. Зарим нэг дутагдалтай талууд гэвэл: буддын шашны сүм хийд, түүхэн дурсгалт зүйлүүд муу нөхцөлд байна. ...Сүм хийдийн орон байшинг үр тарианы агуулах болгосон нь туйлын харамсалтай байна. Өөрсдийн соёл, хөгжил дэвшлийг батлан харуулах хэрэгтэй, соёл иргэншлийг устгагч, дээрэм тонуул хийгчид биш гэдгээ харуулах хэрэгтэй, соёлыг бүтээгч агуу ард түмэн гэдгээ харуулах хэрэгтэй.

Коммунист нэг намын систем нь барууны зочны хувьд сөрөг сэтгэгдэл төрүүлдэг. Бүх зүйл хэтэрхий төвлөрсөн байх бөгөөд хатуу сахилга багтай байна. Сонин, радио, сургуулийн сурах бичиг бүгд нэг дуу хоолойтой ба намын төв хорооны дуу хоолойг илэрхийлж байна. Амьдрал гэдэг олон янз шүү дээ, Карл Маркс, Иосиф Сталин, Ленины хэлсэнээр явахгүй шүү дээ. Янз бүрийн дуу хоолой

² <http://h-turuu.blogspot.com>

³ ГХЯ-ны Төв Архив, 108.2.х9

байх ёстой энэ чинь л барууны ардчилал шүү дээ.миний энэ айлчлал америк, монгол эрдэмтэдийн хооронд харилцаа тогтооход үр дүнгээ өгнө гэж бодож байна.1959 оны 7-р сард Улаанбаатарт болох монгол судлаачдын олон улсын их хурал хуралдуулах нь бидэнд болон та бүхэнд маш их ач холбогдолтой байх болно. . . . Америкийн ард түмэн энх тайванг асар их хүсдэг, энэ хүсэл зориг манай улс төрийн системд шингэсэн байгаа. /гээд хүндэтгэлийн үг хэлж дуусгасан байна.

Түүнчлэн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1-р орлогч дарга нөхөр Цэндээс Америкийн эрдэмтэн Роберт А. Рупений тавьсан БНМАУ НҮБ-д элсэх боломж бололцооны талаар мөн АНУ-тай дипломат харилцаа тогтоох асуудлуудтай холбоотой асуултуудыг тавьж зохих хариултуудыг авсан ба энэ талаар⁴ архивын материалд дурдсан зүйлийг толилуулья:

Асуулт: БНМАУ-ыг АНУ хүлээн зөвшөөрөх явдлыг та хэрэгтэй гэж үзэж байна уу?

Хариулт: Америкийн Нэгдсэн Улсаас БНМАУ-ыг зөвшөөрөх эсэхийг Америкийн Нэгдсэн Улсын Засгийн Газар өөрөө шийдвэрлэх хэрэг юм. Манай улс бүх улсуудтай хэвийн дипломат харилцаа тогтооход бэлэн байгаагаар аль 1921 оны тунхаг ба Америкийн Нэгдсэн Улсын Засгийн Газарт 1921 оны 9-р сарын 12-ны өдөр явуулсан ноотод тодорхойлсон билээ. Үүнтэй холбогдуулан Бүгд Найрамдах Монгол Ард Улс, өөрийн олон улсын харилцааг өргөжүүлэх ба НҮБ-ын ажиллагаанд идэвхитэй оролцохыг хүсч 12 жилийн турш НҮБ-д элсэх тухай асуудлыг нэг бус удаа тавьсаныг дурдууштай байна. Гэвч одоо болтол Америкийн Нэгдсэн Улсын үл тоомсорлох бодлогын уршгаар энэ асуудал зохистойгоор шийдвэрлэгдээгүй байгаа юм. АНУ-аас манай улсыг НҮБ-д элсэхийг саатуулсан ийм бодлого нь Монголын ард түмний зүй ёсны эсэргүүцлийг төрүүлж байгаа болно.

Асуулт: БНМАУ-д АНУ-ын байнгын төлөөлөгчийг суулгахыг Та зөвшөөрөх үү? АНУ-аас БНМАУ-д суух төлөөлөгчийн тооны талаар хязгаар тогтоох уу? АНУ-ын төлөөлөгчид БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр чөлөөтэй бөгөөд ямар нэгэн хязгаарлалтгүй зорчин явж болох уу? Тэдгээр төлөөлөгчид өөрсдийн хүсэлт ёсоор танай албан тушаалын хүмүүстэй уулзаж байж болох уу? Тэд нарт ердийн дипломат хүндэтгэл үзүүлэх үү? Та АНУ-д албан ёсны байнгын төлөөлөгчид явуулах уу?

Хариулт: Америкийн Нэгдсэн Улс ба БНМАУ хоёрын хооронд байнгын төлөөлөгчид солилцох асуудал бол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоохоос шууд хамааралтай бөгөөд тэдний эрх үүргийн тухайд гэвэл харилцан адил үндсэн дээр олон улсын эрхт тогтоосон ёсоор байх нь мэдээжийн хэрэг биз ээ- хэмээн Цэнд дарга хариулсан бөгөөд (эндээс дараагийн асуулт хүртэл мэдээлэл авах тухай ерөнхий асуулт тавьсан байх ба худалдаа хийх боломж, хоёр оронд харилцан суралцах боломж, эрдэмтэд хамтарсан эрдэм шинжилгээний экспедици, судалгааны ажилд оролцохыг зөвшөөрөх эсэх, хөдөө аж ахуйд АНУ-ын тусламж

⁴ ГХЯ-ны Төв Архив, 108.2.x11

авах хүсэлтэй эсэх зэрэг асуултууд асуусан байна. Цэнд тэдгээр асуултуудад “болох юм” гэсэн бөөрөнхийлсөн хариултуудыг өгч байжээ.)

Энэ асуулт хариултыг дүгнэн үзэхэд Р. А. Рупен БНМАУ НҮБ-д элсэх сонирхолтой байгаа эсэх АНУ-тай дипломат харилцаа тогтоох, албан ёсны төлөөлөгчдийг солилцох зэрэг асуудалд хэрхэн хандаж байгаа талаархи хандлагыг ерөнхийд нь тандаж асуусан хандлагатай байна.

*Америкийн нэрт сэтгүүлч Нью Йорк Таймс /New York Times/ сонины тусгай сурвалжлагч Харрисон Эвэнз Солисбери*⁵ 1959 оны 7-р сард манай улсад албан ёсны айлчлал хийсэн ба айлчлах хугацаандаа БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга байсан Ю. Цэдэнбалтай уулзаж сурвалжлага авч байсан.

Солисбери, Ю. Цэдэнбал нар АНУ ба БНМАУ хоёрын хооронд дипломат харилцаа тогтоох тухай мөн түүнчлэн БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнд элсүүлэх талаар ярилцжээ. Х.Солисбери БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудлыг хөндөж асуужээ. Ю. Цэдэнбалын хэлж байгаагаас үзвэл БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхэд гол саад болж байгаа хүчин бол АНУ-гэж ярьсан бөгөөд “хүйтэн дайн”-аас болж хоёр орны харилцаа таагүй байгаа гэж ярьсан байна. Тэгэхээр БНМАУ АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох явдал 1987 оныг хүртэл сунжирсан нь дэлхий дахинаа үүсэн буй болсон “хүйтэн дайн”-тай холбоотой гэдэг нь дээрхи ярианаас илт харагдаж байгаа юм.

Юнайтед Интернейшнл Пресс агентлагийн сурвалжлагч ноён Петер Спрэйг /Peter Sprague/ нь 1956 онд болсон Унгарын бослогыг⁶ биеэр үзсэн бөгөөд тэр аймшигт үйл явдлын талаар фото зураг авч үлдээсэн байдаг. Тэр үед БНМАУ-ын ерөнхий сайд байсан Юмжаагийн Цэдэнбалд Монгол оронд очиж үзэх тухайгаа цахилгаан утас илгээж хүсэлт тавьсан байна. “Манай эхнэр бид хоёр виз авч дэлхийн II дайны дараа Гадаад Монголд айлчилсан гуравдахь эсвэл дөрөвдэхь Америк хүмүүс байлаа” гэж өөрийн блогт дурджээ⁷. П. Спрэйг болон түүний эхнэр номын их билгүүн эрдэмтэн Б. Ренчинтэй уулзаж ярилцахдаа Монголын хязгаар нутагт буй алмасны тухай мөн Монголын түүх, Чингисийн үеэс үлдсэн зүйлүүдийн тухай асууж тодруулав. Б. Ринчин улсын номын санд 100 000 судар, ард олны гар дээр олон сурвалж байгаа гэж хариулж байжээ. Харин хатагтай Төв музейд байдаг Чингис хааны туг, сүлд зэргүүд болон Хүннүгийн булшнаас олдсон эд хогшлуудын талаар асуусан байна.

⁵ Америкийн нэрт сэтгүүлч New York Times сонины тусгай сурвалжлагч Харрисон Эвэнз Солисбери 1908 оны 11-р сарын 14-д Миннесота мужийн Миниполис /Minneapolis, Minnesota/ хотод төрсөн. 1925 онд дунд сургуулийг дүүргэж 1930 онд Миннесотийн Их сургуулийг төгссөн. Тэрээр United Press (UP)-т 20 орчим жил ажиллаж байгаад 1949-1954 онуудад Москвад The New York Times'-ийн Москва дахь товчоонд ажиллаж байв. 1964-1972 онуудад The Times' Op-Ed-д туслах редактор, орлогч редактор зэрэг алба хашиж байв.

⁶ Унгарын бослого 1956 оны 10-р сарын 23-наас 11-р сарын 10 хүртэл 13 хоног үргэлжилсэн бүхэл бүтэн улс орныг хамарсан томоохон эсэргүүцэл байсан юм. Энэ бослого эхэн үедээ оюутны жагсаал хэлбэрээр өрнөж байсан боловч цааш өргөжин тэлж мянга мянган хүнийг хамарсан бослого болж хувирсан билээ. Гэвч Унгарын бослого хэдхэн хоногийн дотор дарагдаж Унгар улс коммунист дэглэмийн дор замнахаас өөр гарцгүй болсон байна.

⁷ <http://sprague.com>

Калифорни муж улсын Станфордын их сургуулийн профессор, эдийн засагч Жорж Морфи Монгол Улстай холбоотой зүйлс ярьсныг ГХЯ-ны архивын материалаас түүж оруулав. Тэрээр: “1959 он хүртэл Монгол Улсын хэвлэл америкт очихгүй байв. Монголын тухай бичсэн зүйлсийг орос хэлээр уншдаг гэнэ. “Цагаан цэцний тууж”, “Нууц товчоо”, орчин үеийн монголын тухай зөвлөлтийн сонин хэвлэлээс уншдаг гэнэ. Монгол Улсыг биеэ даасан тусгаар улс гэж боддог. НҮБ-д зүй ёсоор орох ёстой. Харин америкийн засгийн газраас энэ асуудлын талаар саад хийж байгааг би ойлгохгүй юм гэж яриу. 600 гаруй сая хүнтэй Хятад Ард Улсыг зөвшөөрөхгүй, Тайванийг зөвшөөрсөөр байгааг ойлгохгүй байна. Эйзенхуарын Засгийн Газар солигдож Никсон Ерөнхийлөгч болвол гадаад бодлогод их өөрчлөлт орохгүй байх. Харин ардчилалын намын Кеннеди болвол нилээд өөрчлөлт орж магадгүй гэж бодож байна. Тэгвэл Монгол Улсыг үзэх явдал ч өөр болж мэднэ”-гэж яриу. Түүнчлэн Монгол Америкийн хооронд улс төрийн харьцаа тогтохоос өмнө, соёл, эдийн засгийн харьцаа тогтоож болох юм. Хэрэв Монгол хүмүүс Америкт очих виз олох юм бол танай бизнесменүүдийг хүлээн авч болно.

Станфордын их сургуульд гадаадын зочдыг хүлээж авах фонд ч байдаг. Станфордын их сургууль Монголын талаар 3 боть ном хийсэн, мөн Майскийн “Орчин үеийн Монгол Улс” гэдэг номыг Англи хэлэнд орчуулсан. Би нутагтаа очоод Монгол Улсын талаар бодитой зүйлийг бичнэ гэж ярьсан. Ах дүү социалист орнуудын хувьд хөгжиж байгаа Монгол-Хятадын харьцааг ойлгохгүй, Зөвлөлт, Хятадын харьцаа нь Монголын талаар өрсөлдөөнтэй байна гэдэг ойлголттой юм шиг байна. **Бусдаас тусламж авч байгаа буурай хөгжилтэй Хятад улс Монголд өдий их тусламж үзүүлж байгаа нь ердөө л улс төрийн бодлого** гэж ярьж байна-хэмээн өгүүлжээ.

АНУ-ын эрдэмтэн Удо Пош Монголч эрдэмтэдийн олон улсын их хурлын тухай: “ “Миний амьдралдаа үзсэн конгрессуудын дотор монголч эрдэмтэдийн энэ конгресс хамгийн сайхан нь боллоо. АНУ-аас Монгол Улсыг одоо болтол хүлээн зөвшөөрдөггүй нь мунхаг хэрэг юм. Латтимор зэрэг нэртэй эрдэмтэд бол танай улсыг хүлээн зөвшөөрүүлэх эрмэлзэлтэй байдаг. **Би нутагтаа очоод, Монгол Улсыг хүлээн зөвшөөрөх асуудлыг өөрийн сенаторуудад тавина. Америк Монголын хооронд соёлын харилцаа тогтооё: оюутан, эрдэмтэн солилцох зэрэг ажлыг зохиоё, энэ бол Америкаас танай орныг хүлээн зөвшөөрч, улс төрийн харьцаа тогтооход чухал алхам болно”- гэж ярьж байжээ.** Энэ эрдэмтэн БНМАУ, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох нь чухал ач холбогдолтой гэж үзсэн бөгөөд энэ талаар Сенатын гишүүдэд тавих талаар санал дэвшүүлжээ. Дипломат харилцаа тогтоохгүй ч гэсэн боловсрол, соёлын харилцаа тогтоож эрдэмтэн, оюутнуудыг солилцох нь зүйтэй гэж үзэж байв. Энэ мэтээр хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлыг дэмжиж, энэ талаар эерэг үзэл санаатай олон эрдэмтэн, судлаачид, албаны хүмүүс байсан.

Нэрт Монголч эрдэмтэн О. Латтиморын⁸ БНМАУ, АНУ-ын харилцаанд гүйцэтгэсэн үүрэг

О. Латтимор дунд сургуулиа дүүргээд Хятадад буцан ирж Тъянжин болон Пекин Таймс /Бээжингийн цаг үе/ /Tientsin and Peking Times/ зэрэг сонин хэвлэлийн газар ажиллаж байгаад Хятадын баруун нутгаар худалдаа наймаа хийж явжээ.

1925 онд баруун Хятад, Монгол орноор аялж явсан бөгөөд энэ бүс нутгийн талаар Харвардын их сургуульд /Harvard University/ 1928-1929 онуудад судалгаа хийж байв. Дараа нь 1930 оноос 1933 он хүртэл Бээжинд ажиллажээ.

1938-1963 онуудад Жон Хопкинзын их сургуулийн Олон улсын харилцааны сургуулийн захирлаар ажиллаж байжээ. Захирал байхдаа Монголд айлчлах хүсэлтээ Маршал Чойбалсанд гаргажээ. Гэвч Х. Чойбалсан түүний захидалд тодорхой хариулт өгөөгүй байна. 1948 онд Нанжин дахь АНУ-ын элчин яам Латтимортой холбоо барьж Коммунизмын эсрэг үндэсний хөдөлгөөнд идэвхитэй оролцогч Хангины Гомбожав, Өрөнгөө Онон нарыг АНУ-д суурьшуулах асуудлыг тавьжээ. Тэрээр тэднийг сургуульдаа тэтгэлгээр ажиллуулж эхлэв. Тэнд тэр хоёр Дилав хутагттай уулзаж Монгол судлалыг хөгжүүлэхээр болжээ. 1950 оны 3-р сард улс төрийн комментатор Дрю Пийрсон гэгч хүн Дилав Хутагт, Өрөнгөө Онон, Хангины Гомбожав, Оуэн Латтимор нарыг коммунист тагнуулууд гэж нэрлэн олон нийтэд радио нэвтрүүлгээр мэдээлсэн байна. Энэ үйл ажиллагаа тэдэнд маш том цохилт болжээ. 3-р сарын 27-нд болсон хэвлэлийн бага хурал дээр Дилав хутагт: “Би 1931 онд Гадаад Монголоос зугтан гарахдаа Латтиморийг мэддэг болсон, энэ хүнийг коммунист хүн гэж би үзэхгүй байна гэж хэлжээ. Гомбожав, Өрөнгөө нар Латтимор Монголын коммунистуудтай ямар ч холбоогүй харин Өвөр Монголын коммунизмын эсрэг үндэсрэхг хөдөлгөөнийхөнтэй холбоотой байсан гэж хэлжээ.”⁹

1941 онд АНУ-ын ерөнхийлөгч Франклин Рузвельтийн шийдвэрээр О. Латтимор Хятадын үндэсрэхг намын удирдагч Чан Кайшигийн улс төрийн зөвлөхөөр жил хагасын хугацаанд томилогдон ажиллажээ. О. Латтимор дэлхийн II дайн дуусах дөхсөн үе буюу 1944 онд АНУ-ын суртал, нэвтрүүлэг, ухуулга мэдээллийн байгууллага болох Дайны мэдээллийн албаны захирлаар ажиллаж эхэлсэн. Дайны дараа Америк даяар “Улааны айдас” гэсэн нэрийн дор коммунизмын аюулаас айн дагжиж түүний эсрэг МкКарти тэргүүтэй кампанит ажил хүчтэй өрнөж энэ давалгаанд Латтимор өртөн хэлмэгдэж түүний албан ажил, Америк дахь монгол судлалын хөтөлбөр нь ч хүртэл зогсоход хүрчээ. Ийнхүү гүтгэгдэн хэлмэгдсэн тухайгаа “Хэлмэгдэхийн зовлон” номондоо яруу тод дүрслэн бичсэн

⁸ Оуэн Латтимор нь Төв Ази ялангуяа Хятад, Монгол судлалаар мэргэшсэн АНУ-ын нэрт эрдэмтэн юм. 1900 оны 7-р сарын 29-нд Вашингтон хотод Дэвид, Маргарет нарын хүү болон төрж 1989 оны 5-р сарын 31-д 89 насандаа таалал төгсжээ. Түүний эцэг Тъянжинд Франц, Герман, Испани хэл зааж байсан тул хүүхэд насаа Хятадад өнгөрүүлжээ. Европт суралцуулахаар түүнийг арван хоёр настайд нь явуулсан. Швейцарын Коллеж Класик Кэнтонэл /College Classique Cantonal/-д 1913-1914 онуудад суралцаж дараа нь 1915 оноос 1919 оны хооронд Английн Ст. Бийз Сүүүл /St. Bees School/ сургуульд суралцсан байна.

⁹ К. Алисия, Р. Баасан, 20-р зуун дахь Монгол, АНУ-ын улс төрийн харилцаанд үзүүлсэн Хятад, Оросын нөлөөлөл, х 327

гэдэг. “Зөвлөлтийн тагнуул, туршуул” гэсэн зүйл ангиар түүнийг буруутган 2 жил гаруй байцаасны эцэст хилсээр ялласан байна. Гэвч 1955 онд Холбооны шүүх эл ялыг цуцалжээ.

О. Латтимор Их Британы Лийдсийн их сургуульд 1963 оноос ажиллахаар болж тэнд шилжин ирсэн байна. Тэрээр Лийдсийн их сургуульд хятад судлалын тэнхим байгуулж дараа нь монгол судлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэн Монголын түүх, соёл, хэлийг зааж эхэлсэн. “1970-аад онд тэрээр Лийдс дэх Монгол судлалын тэнхимд дипломын дараахь шатны сургалт зохион байгуулан өөрөө түүхийн хичээл, харин Өргөнгөө Онон монгол хэл заах болжээ. Шавь нартаа “Ла багш” хэмээгддэг тэрээр ихэд нөхөрсөг нэгэн байсан бөгөөд монгол хэлдээ гаргуун, онигоог ч наргиан хөгжөөнтэй ярьж чаддаг байжээ.”¹⁰ О. Латтимор Монголын төлөө гэсэн сэтгэлтэй байсан бөгөөд Монгол судлалыг дэлхий дахинаа өргөжүүлэн хөгжүүлэхэд асар их хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм. Түүний Монголын төлөөх их үйлсийг манай орны төр, засаг өндрөөр үнэлэн “Алтан гадас” одонгоор шагнаж байсан.

Дэлхийн дайн эхлэсний дараа 1941 онд Хятадын үндсэний засгийн газрын удирдагч Чан Кайшигийн хувийн америк зөвлөхөөр ажиллахаар томилогджээ. Тэнд жил гаруй ажиллаад Америктаа буцан ирж Pacific Affairs /Номхон далайн асуудал/ сэтгүүлийн редактороор ажиллаж байжээ. О. Латтимор “Туркестанд хөтөлсөн говийн зам”, “Манжуур: зөрчилдөөний өлгий”, “Манжуурын Монголчууд”, “Азийн нөхцөл байдал”, “Монгол дахь үндэсний үзэл ба хувьсгал” /Ш. Нацагдорж нарын хамтын бүтээл/, “Нүүдэлчид ба комиссарууд” зэрэг ном бүтээлүүдийг туурвижээ.

О.Латтимор Монгол судлалыг хөхиүлэн дэмжих, хөгжүүлэн дэлгэрүүлэх талаар асар их ажил хийж байсан боловч түүний зам дардан сайхан байсангүй. АНУ-ын эрх мэдэлтэнгүүдэд коммунизмын тагнуулч гэж гүтгүүлэн сэтгэл санааны их шаналалд унаж шоронд орох шахаж байлаа.

Дэлхийн II дайн дууссаны дараа сенатор МкКарти Латтиморыг Зөвлөлтийн тагнуулч байсан гэж гүтгэж эхэлсэн ба үүний гол учир нь Чан Кайшигийн гоминданы арми АНУ-аас хэдэн тэрбум долларын тусламж дэмжлэг авсан боловч ялагдал хүлээж, БНХАУ байгуулагдсаны улмаас Америкийн ганц хүчтэй өрсөлдөгч ЗХУ буюу коммунист лагерын цар хүрээ өргөжин тэлсэн, ЗХУ цөмийн зэвсэг туршин АНУ-ыг айлгаж эхэлсэн, мөн сансарт пуужин хөөргөж, нохой нисгэн туршиж, эцэстээ хүн нисгэсэн явдал АНУ-ыг сандралд оруулж сансарт ноёрхлоо алдахаас зүрхшээн айж байлаа. Хятадад АНУ-ын талыг баримтлагч Гоминданы арми коммунист Хятадуудад ялагдсан нь АНУ-ын гадаад бодлогод том цохилт болсон юм. Иймд энэ “ялагдлын” буруутанг олж шийтгэн олон нийтийн бухимдлыг арилгах нь АНУ-ын хувьд чухал зүйл болж хувирав. Энэ тухай Р. Болд: Монголын тусгаар тогтнол ба АНУ номондоо: “...ТД /Төрийн департамент. Горилогч/ Хятадын талаархи бодлогоо хянан үзэх тусгай хороог 25 шинжээчийн бүрэлдхүүнтэй байгуулсны дотор О. Латтимор оржээ. БНХАУ-ыг хүлээн зөвшөөрөх, эсэх талаар

¹⁰ Тив дамнанас хөршүүд, ОУСХ, ШУА, УБ 2014 он

шинжээчид санал зөрөлдөж, Пенсилваний Их Сургуулийн захирал Х.Стассен тэргүүтэй 5 шинжээч эрс эсэргүүцэж, О. Латтимор тэдний байр суурийг ширүүн шүүмжилжээ. Сүүлд Стассен Хятадыг “алдсаны” гол буруутан нь Латтимор гэж Сенатад мэдүүлэг өгч байв. Төрийн нарийн бичгийн дарга Д. Ачесон хэвлэлийн бага хурал дээр “Хятадад юу болж байна вэ гэвэл Хятадын умард мужуудыг ЗХУ Хятадаас салган өөртөө нэгтгэж байна. Энэ үйл явц ар Монголд дуусчээ” гэж 1950 оны 1-р сарын 12-нд мэдэгдсэн байна.¹¹ “Хүйтэн дайн”-ы үед сэтгэл зүй, үзэл санааны дайн өрнөж, тусгаар тогтноод удаагүй байсан Хятад улс коммунист замаар замнах болж Чан Кайши тэргүүтэй Америкийн тал баримталсан Хятадууд ялагдал хүлээж Тайваньд зугтан гарсан нь АНУ-ын улсын хувьд туйлын том цохилт болж энэ хэргийн тавин хувийг Хятадын талд хариуцуулж, үлдсэн тавин хувийг Латтиморт тохоосон байна. А. Бармине гэгч О. Латтиморыг “Зөвлөлтийн тагнуул” гэж мэдүүлсэнээс үүдэн түүнийг нарийвчлан шалгахыг даалгасан байна. “Энэ нь Монгол судлал, Монголтой холбоотой бүх асуудлууд шалгагдана гэсэн хэрэг байв. Конгрессын гишүүн ирээдүйн Ерөнхийлөгч Ж. Кеннеди 1949 онд “Хятад дахь америкийн дипломатууд, тэдгээрийн зөвлөх Латтимор, Файрбанкс нарын алсын хараагүй харалган бодлогын улмаас Хятадын талаарх Америкийн бодлого дампуурлаа” хэмээн шүүмжилж байв.¹² Сенатч Мккарти, Латтиморыг “Зөвлөлтийн тагнуул” гэсэн нэр зүүж түүнийг сайтар шалган мөрдөж цаашлаад улс төрийн тавцангаас цэвэрлэхийг шаардаж түүгээр зогсохгүй Ачесон¹³, Маршалл¹⁴ зэрэг хүмүүсийг хүртэл буруутгаж байлаа. Сенатч Мккарти БНМАУ-ыг тусгаар тогтож биеэ даасан улс гэж үздэггүй байсан төдийгүй Оросын колони гэж үзэж байжээ. Тэрээр коммунизмтай тэмцэх нэрийн дор 81 хүний нэрсийг гаргаж тэднийг гүтгэн буруутгаж эхэлсний тоонд Латтимор орсон байна. Тэрээр олон зуун хүнийг хилс хэрэгт гүтгэж хэлмэгдүүлж байсан нь Америкийн түүхэнд “Мккартизм” гэж нэрлэгдэж байв.

АНУ-ын Холбооны Мөрдөн Байцаах Товчооны захирал Хуверын тушаалаар хоёр ажилтан арван хоёр өдрийн турш Латтимороос түүний талаар авсан бүх мэдээллийн дагуу мэдүүлэг авч 134 хуудас материал бэлтгэжээ. ХМБТ¹⁵-ны зургаан шинжээч хоёр сарын турш Латтиморын бичсэн 125 бүтээлийг коммунист чиг шугамтай нийцэж байгаа эсэхийг тогтоохоор ажиллаж ХКН¹⁶, Латтиморын дүгнэлтүүд ижил төстэй байна гэж үзжээ. Латтиморыг илчлэхээр хэдэн зуун хүн Мккартигийн ажлын албанд хандаж байсан нь Америкийн нийгмийн тухайн үеийн сэтгэл зүйг харуулна. Латтимор сенатын 10 гишүүн оролцсон Тайдинсийн хорооны хуралдаанд гүтгэлгийг няцааж, өөрийгөө хамгаалан бараг хоёр цаг ярьжээ. Түүний

¹¹ Р. Болд, Монголын тусгаар тогтнол ба АНУ, УБ 2008 он, х 224

¹² Р. Болд, Монголын тусгаар тогтнол ба АНУ, УБ 2008 он, х 225

¹³ АНУ-ын Ерөнхийлөгч Харри Трумены засаг захиргааны үед /1949-1953/ Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан

¹⁴ АНУ-ын төр, цэргийн зүтгэлтэн армийн генерал, Маршаллын төлөвлөгөөг боловсруулсан, Нобелын шагнал хүртсэн, АНУ-ын батлан хамгаалахын сайд, 1947-1949 онуудад Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан

¹⁵ Холбооны Мөрдөн Байцаах Товчоо

¹⁶ Хятадын Коммунист Нам

үгийг америк даяар чих тавин сонсож байжээ. Латтимор сенатч Мккартигийн мэдэгдэлд Монголыг дайран давшилсан хэсэг нь Оросын ач холбогдолгүй эх сурвалжаас авсан, оновчгүй болохыг баримтаар няцаажээ.¹⁷ Латтимор 1952 онд нийтлүүлсэн “Зөвлөлт-Хятадын хоорондох гүүр” өгүүлэлдээ “Ар Монгол нь дагуул улс, 1911-1918 онд Хаант Оросын, Оросын хувьсгалын дараа Зөвлөлтийн дагуул тус тус байснаасаа илүү дагуул болжээ. Гэхдээ дагуулын үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ хэлбэр бүтцийн хувьд бүрэн эрхт улс байна” гэж бичжээ.¹⁸

АНУ-ын сенатор Мензфийлдийн¹⁹ БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтооход гаргасан хүчин зүтгэл: Майк Мензфийлд АНУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтооход нилээд хүчин зүтгэл гаргаж байв. 1945 оны Монголын ард түмний бүх нийтийн санал хураалт болоход АНУ-ын төлөөлөгчийн танхимд шинээр сонгогдсон залуухан Мензфийлд Хятадын бодлогыг дахин хянаж үзэхийг шаардаж, Монгол Улсыг биеэ даасан, өөрийн гэсэн соёл, ёс заншилтай, тусгаар улс юм гэж үзэн АНУ-ын засгийн газраас Монгол Улсыг хүлээн зөвшөөрөхийг шаардаж байв. Хэдийгээр тэр АНУ-ын гадаад бодлогод хүчтэй нөлөөлөн өөрчилж чадаагүй ч Монголын талаархи АНУ-ын бодлогыг нааштай болгож чадсан юм. 1960 онд Мензфийлд хоёрдахь удаагаа Монгол Улсыг хүлээн зөвшөөрөх асуудлыг хөндөн тавьж энэ нь АНУ-ын гадаад бодлогод асар их нөлөө үзүүлж байсан байна.

1950 онд БНХАУ болон ЗХУ-тай дипломат харилцаа тогтоосон байсан ба 1955 онд эвслийн бус хөдөлгөөний тэргүүн орон болох Энэтхэг улс БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч харилцаа тогтоосон байлаа. Гэвч бусад капиталист гүрнүүд БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоох алхам хийхийг хүсэхгүй байв. Харин БНМАУ НҮБ-д элсэхийн төлөө хүчин чармайлт гаргасаны хүчинд 1961 оны 10-р сарын 27-нд албан ёсоор элсэн орсон. 1958 онд Мензфийлдийг НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 13-р чуулганд Ерөнхийлөгч Эйзенхуар түүнийг АНУ-ыг төлөөлсөн төлөөлөгчдийн нэгээр томилж явуулсан нь Монгол Улсыг тойрсон, гишүүн болохтой холбоотой асуудлууд маш ихээр босож байгаа явцыг гүн гүнзгий ойлгож авсан байна. 1960 оны 4-р сарын 19-нд сенатор Мензфийлд, Нью Йорк Таймс сонинд Х.Солисберийн хэвлүүлсэн өгүүлэлүүдийг уншиж Монголын тухай нилээд мэдээлэл олж авч Орос, Хятадын аль алинд харьяалагддаггүй, тусгаар улс хэмээн АНУ-ын засгийн газарт танилцуулж энэ оронтой дипломат харилцаа тогтоохыг зөвлөж байжээ. Энэ оронтой харилцаа тогтоовол Азийн гүнд нэвтрээд зогсохгүй мөн Орос оронд ойртох боломж гарах юм. Ардчилсан эсвэл бүгд найрамдах намын алиний ч засаг захиргаа байсан ялгаагүй Гадаад Монголтой харилцаа тогтоох асуудлыг шийдэх хэрэгтэй-гэж тэр үзэж байв. Мензфийлд АНУ-

¹⁷ Р. Болд, Монголын тусгаар тогтнол ба АНУ, УБ 2008 он, х 225

¹⁸ Owen Lattimore “Inner Asia: Sino-Soviet Bridge” Studies in Frontier History, 1962 p// 160

¹⁹ АНУ-ын улс төрч, нэрт дипломатч Майкл Жозеф Мензфийлд нь /1903.03.16-2001.10.05/ Ардчилсан намын гишүүн бөгөөд 1943-1953 онуудад АНУ-ын төлөөлөгчийн танхимд ажиллаж, 1953-1977 онуудад АНУ-ын сенатораар Монтана мужаас сонгогдон ажиллаж байв. 1961-1977 онуудад Сенатын олонхийн тэргүүнээр ажиллаж байхдаа Вьетнамын дайныг ширүүн эсэргүүцэгч байсан. Монтангийн Их сургуульд магистрын зэрэг хамгаалж дараа нь докторын зэрэг хамгаалсан байна.

ыг Монголтой дипломат харилцаа тогтоон хүлээн зөвшөөрөх, НҮБ-д элсэхэд дэмжих талаар уриалж байлаа. “Бид яагаад Гадаад Монголтой харилцан бие биенээ таньж мэдэхийн тулд төлөөлөгчидөө солилцож болохгүй байгаа юм бэ? Ингэснээр бид Гадаад Монголтой дипломат буюу өөр төрлийн харилцаа тогтоож болох юм. Хэрэв Гадаад Монголын засгийн газар НҮБ-д элсэх хүсэлтээ гаргавал АНУ үүнд саад хийх хэрэггүй” гэж хэлж байжээ. АНУ-д суугаа Зөвлөлтийн элчин сайд М. Меншиков, АНУ Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоохыг ЗХУ-ын хувьд таггалзах зүйлгүй гэдгийг Мензфийлдэд хэлж байв. БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох нь Эйзенхуарын засгийн газрын гадаад бодлогын гол зүйлийн нэг биш байв. Харин Мензфийлд Монголтой харилцаа тогтоох асуудлаар Төрийн департаментын зарим нэг албаны хүмүүст тодорхой хэмжээгээр нөлөөлж чадсан. Жон Кеннедийн засаг захиргааны үед Монголтой дипломат харилцаа тогтоох оролдлого хийж байсан. Төрийн департаментийн нарийн бичгийн даргаар томилогдсон Дийн Раск Гадаад Монголтой харилцаа тогтоох асуудлыг дахин судалж үзэж байгаа тухай Ерөнхийлөгч Жон Кеннедид мэдээлж байв. Тэр үед Мензфийлд Сенатын гадаад харилцааны хорооны даргаар ажиллаж байсан бөгөөд Гадаад Монголтой дипломат харилцаа тогтоох асуудлыг ихэд дэмжиж Сенатад хүртэл нөлөөлж байв.

Р. Болд “Монголын тусгаар тогтнол ба Америкийн Нэгдсэн Улс” номондоо: “Ерөнхийлөгч Кеннедийн хүсэлтээр Монтана мужаас сонгогдсон Мензфийлд²⁰, Сенатын олонхийн удирдагчаар 1961 онд сонгогдсон юм. Мензфийлд Кеннедитэй ойр дотно харилцаатай, түүнийг Монголыг хүлээн зөвшөөрөх санаачлага гаргахад голлон нөлөөлсөн улс төрч.

Ийнхүү АНУ-ын эрдэмтэн Роберт А. Рупен, Х. Солисбери, Удо Пош, О. Латтимор, М. Мензфийлд зэрэг хүмүүс Монгол орныг АНУ төдийгүй дэлхий дахинаа таниулан сурталчилж, БНМАУ ба АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох, НҮБ-д элсэн орох зэрэг өргөн хүрээтэй, улс орны хувьд амин чухал асуудлаар Монголчуудын талд баттай зогсож, зүрх сэтгэлээ зориулан тэмцэж байсан нь бид бүхний бахархалыг төрүүлдэг.

НОМ ЗҮЙ

1. Alicia Campi and R. Baasan, The Impact of China and Russia on U.S.-Mongolian Political Relations in the Twentieth Century
2. Baatar. Ts, “The Chinggis Heritage in the USA: Mongolian Americans in the 20th Century”, UB 2001
3. Bruce B. Knaut, Richard Taupier, “Mongolians After Socialism: Politics, Economy, Religion”, UB 2012
4. Deborah Welch Larson, Anatomy of Mistrust, U.S.-Soviet Relations during the Cold War, Cornell University Press, 1997
5. Harvey Schneider, Mongolia between Russia and China, 1953-1965

²⁰ Р.Болд номондоо Мансфелд гэж орчуулсаныг англи дуудлагыг үндэслэн Мензфийлд болгов

6. Oxford Monsudar English Mongolian Dictionary
7. The 30-year War /1945-1975/, Hanoi 2001
8. Theoder C. Sorensen, “Kennedy”, New York
9. Алтангэрэл, Ц. Дипломат баримт бичгийн орчуулга. УБ 2007
10. Алтангэрэл, Ц. Орчин цагийн Англи Монгол холбоо үгийн толь бичиг. УБ 2015
11. Америкийн консул Сокобин Монголын тухай, орчуулсан Р. Болд, УБ 2017
12. Америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгчийн засаглал, /ШУА-ын олон улс судлалын хүрээлэн, АНУ-ын элчин сайдын яам
13. Ариунсанаа, Т. Олон улсын харилцаа /дэлхийн бодлого зүйн удиртгал, системийн хандлага/ УБ 2012, х-79-80
14. Баатар, Ц. Глобалчлалын эриний Америкийн эдийн засаг. УБ 2004
15. Баярхүү, Д. Евроазийн геополитик, олон улсын харилцаа /өнгөрсөн, одоо, ирээдүй/
16. Баясах, Ж. Монгол Улс ба хөрш орны гадаад бодлого, УБ 2015
17. Болд, Р Монголын тусгаар тогтнол ба АНУ /1910-1973/, УБ 2008
18. Болдбаатар. Ж, Батбаяр. Ц, “Монгол, Хятадын харилцааны түүхийн зарим асуудал”, УБ 2011
19. Дашзэвэг. Б “Монгол-Америкийн харилцааны түүхийн чухал асуудал”, УБ 2010
20. Жонатан Эдлтон, АНУ-Монгол Улсын дипломат харилцаа /1987-2012/, УБ 2012
21. Ишжамц, Н. “АНУ-аас Монголд явуулсан бодлого: Монгол-АНУ-ын харилцаа 1900-1987”
22. Монголын улс төрийн гадаад харилцааны түүх /1911-1990 он/
23. НҮБ, Монголын хамтын ажиллагаа-United Nations Mongolia Cooperation, УБ -2005 он, х-31
24. Саруул-Эрдэнэ. М, “АНУ-ын Монгол судлаачид”, УБ 2015
25. Уламбаяр, Д. Монгол Улс, өрнө дахин: харилцаа, хамтын ажиллагаа. УБ., 2007 он
26. Хурметхан, М. Монгол Америкийн харилцаа ба Америк судлал. УБ 2003
27. Хурметхан, М. Монгол Улс-Америкийн нэгдсэн улсын иж бүрэн түншлэлийн эхэн. УБ 2007
28. Цолмон, Д. Америкийн Нэгдсэн Улсын түүх, УБ 2011

